

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ИХ СУРГУУЛЬ**

Чойжилсүрэн Гансүх

**IFN_γ болон азотын дан исэл судас хатууралд
нөлөөлөх нь**

(E 720218 Дархлаа судлал)

**Анагаах ухааны магистрын зэрэг горилсон бүтээлийн
хураангуй**

**Улаанбаатар
2007**

Энэхүү ажлыг ЭМШУИС (Захирал, профессор Ц.Лхагвасүрэн), Био-Анагаахын сургууль (Захирал, Дэд профессор Г.Батбаатар), Бичил-амь, Дархлаа судлалын тэнхим (Эрхлэгч, дэд профессор Г.Батбаатар) Үйл-Оношийн лаборатори, Дархлаа судлалын лаборатори, Шастины нэрэмжит нэгдсэн 3-р эмнэлэгийг (Дарга Б.Батчулуун) түшиглэн хийж гүйцэтгэв.

Магистрын ажлын удирдагч:

АУ-ны доктор, дэд профессор Г.Батбаатар

Био-АС-ийн Эрдэмтдийн зөвлөлийн нарийн бичгийн дарга
АУ-ны доктор, дэд профессор Чимэдцэрэн

Үндэслэл

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын мэдээлсэнээр (2002) зүрх судасны өвчин нь нас баралтын тэргүүлэх гол шалтгаан болж байна [1]. Зүрх судасны өвчний улмаас жилд 16.7 сая хүн нас бардаг ажээ. Үүний 7 сая нь титэм судасны эмгэгийн улмаас, 6 сая орчим нь цус харвалтын шалтгаантай байдаг [2].

Америкийн Нэгдсэн Улсад нийт хүн амын үхлийн шалтгааны 50 орчим хувийг атеросклероз болон түүний хүндрэлүүд эзэлдэг. Жилд 500000 гаруй хүн зөвхөн зүрхний шигдээсийн тохиолдолын улмаас нас бардаг [3]. 2002 онд манай улсад зүрх судасны тогтолцооны өвчлөл 10000 хүн ам тутамд 449.5, зүрх судасны өвчнөөс шалтгаалсан нас баралт 22.3 байсан бол 2004 онд 10000 хүн ам тутамд 504.4, зүрх судасны өвчнөөс шалтгаалсан нас баралт 23.1 (10000 хүн ам тутамд) болж өссөн байна [4,5]. 1990 оноос хойш зүрх судасны тогтолцооны өвчлөл жилээс жилд өсөж байгаа бөгөөд энэ нь нас баралт болон хөдөлмөрийн чадвар алдалтын гол шалтгаан болсоор байгаа билээ.

Судлаачид атеросклерозын эмгэгжамд дархлаа тогтолцоо болон судасны эндотелийн үйл ажиллагааны алдагдал чухал үүрэгтэй болохыг тэмдэглэсэн байдаг [6].

IFN γ (Interferon γ) нь Th1 (T helper 1) эсээс ялгардаг үндсэн цитокин бөгөөд атеросклерозын эмгэгжамд гол үүрэг гүйцэтгэдэг болохыг сүүлийн үеийн судалгаанууд харуулж байна [7].

Монгол улсад атеросклерозын эмгэгжамд ийлдсийн липидийн агууламж болон эрсдэлт хүчин зүйлүүдийн үзүүлэх нөлөөллийн талаар хэд хэдэн судалгаа хийгдсэн боловч интерферон гамма болон азотын дан ислийн нөлөөллийг харьцуулан судалсан ажил одоогоор хийгдээгүй байгаа юм.

Иймээс бид судас хатуурах өвчин үүсэхэд дархлааны хүчин зүйлсийн нөлөөллийг тодорхойлох оролдлого хийлээ.

Судалгааны ажлын зорилго

Бидний судалгааны ажлын зорилго бол атеросклерозын эмгэгжамд IFN γ болон азотын дан исэлийн нөлөөллийг харьцуулан судлах байлаа.

Судалгааны ажлын зорилт

1. IFN γ -ийн өөрчлөлт атеросклерозын эмгэгтэй хэрхэн хамааралтайг тодруулах
2. Ийлдсийн азотын дан исэл судас хатуурлын үед хэрхэн өөрчлөгдөх зүй тогтлыг тодорхойлох
3. Цусны урсгалын хурд судасны өөрчлөлтийн хамаарлыг тогтоох зорилгыг дэвшүүлэн шийдвэрлэлээ.

Судалгааны ажлын шинэлэг тал:

- Атеросклерозын эмгэгжамд IFN γ -ийн нөлөөлөх нөлөөллийг тодорхойлсонд,
- Азотын дан ислийн өөрчлөлтийг IFN γ -ийн агууламжтай харьцуулан судалсанд оршино.

Судалгааны ажлын практик ач холбогдол:

Атеросклерозын эмгэгжамд нөлөөлөх Азотын дан исэл, IFN γ -г тодруулснаар түүнээс урьдчилан сэргийлэх, оношлогоо эмчилгээний асуудлыг шийдэхэд дөхөмтэй болно.

Био-анагаахын ёс зүйн асуудал:

ЭМШУИС-ийн Бионагаахын ёс зүйн зөвлөлийн 2006 оны 3 сарын 3-ний өдрийн хурлын №28/3 тоот тэмдэглэлээр зөвшөөрөгдсөн судалгаанд оролцогсдын таниулах хуудсаар /хавсралт 2/ нийт 43 хүнийг өөрсдийнх нь хүслээр судалгаанд хамрууллаа.

Бионагаахын судалгаа хийж буй судлаачдад тавигддаг ёс зүйн хэм хэмжээ, шаардлагын дагуу, бионагаах ухааны судалгаанд хүнийг хамруулах тухай олон улсын ёс зүйн удирдамжын дагуу судалгааг явуулав.